


та гэмжих үү ?

Ж.Ж. Дэмжиж байгаа. Хилчин хүн хилээ судлах, түүнийг сурталчлах хилчид, хязгаар нутгийнхныг анхаарах нь ухаалаг, үнэ цэнэтэй амьдрал мөн. Товчоор хэлэхэд хил, хилчин гэдэг түүхэн агуулгыг залгамж үед ойлгуулах, мэргэжүүлэх тухай санаа юм. Манай сэхээтнүүд эрдэмтэн мэргэдээс шинэчлэлд оруулж байгаа шинэ хувь нэмэр хэмээн үзэж сайшааж байна.

Сэтгүүлч Ш.Доржбал хөөрөлдөв



Уран зохиол

*Монгол Улсын Соёлын зүтгэлтэн
Ч.ДАГВАДОРЖ*



Утга зохиолын судлагч, шүүмжлэгч, яруу найрагч Ч.Дагвадорж 1942 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод Дэлгэрмөрөнний дэнжид малчны гэрт төрж мэндэлсэн.

Утга зохиолын шүүмжлэгчдийн Олон улсын холбооны гишүүн, МҮЧЗХ-ны шагналт, “Морин хуур-1990”, “Цагаан лавайн эгшиг” шилдэг дууны уран бүтээлийн дэд, тэргүүн шагналт, Монголын анхны хураангуй нэвтэрхий толийг зохиож дуусгасан хариуцлагатай редактор, МУИС-ийн проффеесор, Хэл бичгийн ухааны доктор.

“Номоос төрсөн бодол”, “Монголын орчин үеийн уран зохиол дахь ажилчин ангийн дүрийн хөгжилт”, “Цаг үе, уран бүтээл, шүүмжлэл”, “Цэргийн албаны гоо зүй” зэрэг нэг сэдэвт болон судалгаа шинжилгээний номууд “Далийн үзэг”, “Далайн цэнхэр салхи”, “Ээж минь дээ”, “Сэтгэлийн амраг”, “Атга шороо”, “Нугас алаг нүд”, “Хойд Америкийн намар” зэрэг шүлэг, найраглал, дууны түгвэр хэвлүүлжээ.

Ч.Дагвадоржийн шүүмж, яруу найргийн бүтээл нь Орос, Итали, Франц, Хятад улсад хэвлэгдэж, “Ээж минь дээ”, “Аавдаа дуулсан дуу” зэрэг шилдэг дуу нь Хятад, Япон сонсогч үзэгчдэд хүрчээ. Ч.Дагвадоржийн уран бүтээлд нь эх орон, дархан хилийн сэдэв тодорхой байр эзэлдэг. Түүний эх орон хилийн сэдэвт найраг шүлгээс манай сэтгүүл уншигчиддаа толилуулахын ялдамд түүний мэндчилгээг бас давхар

уламжилъя. “Онолтой турилагатай хилчин, эрдэмтэн хурандаа Г.Дагважамц нарын зэрэг хэсэг нөхдийн санаачлагаар “Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг” байгуулагдсанд гүнээ талархаж, “Дархан газар шороогоо ч сэмлүүлэхгүй, эгнэгт бат эзэгнэж явахад хилчид хязгаар нутгийнхны төлөө их зүйл хийнэ гэдэгт итгэн тус нийгэмлэгийг дэмжиж гишүүн болсны хувьд сэтгэлийн үгээ өргөмүч.

ЭХ ОРОН МИНЬ ӨРШӨӨ НАМАЙГАА

Цээжиндээ тэвэрсэн ээжийгээ хад дэрлэхэд

Цэнгийн төдий нулимс унагаагүй алдас бий, өршөө намайгаа!

Цэх журамт эцгийгээ уул дэрлэхэд адис аваагүй алдас бий, өршөө намайгаа!

Газар нутаг минь гандаж хүн ард минь сэмэрч байхад

Ганцхан биений жаргал хөөсөн алдас бий, өршөө намайгаа!

Хотонд ганцуй зөнөсөн нохой хүртэл

Хонд бууцандаа хоргодсоор эвхэрдэг байхад

Ховор эрдэнэт монгол хүний төрлийг олсон байтлаа

Хотол монголын өлгий эх орноо гээсэн алдас бий, өршөө намайгаа!

Амьтны ад болсон муу ёрын хулгайч хүртэл

Ариун дагшин эх орон юугаа мартаагүй байхад

Амар түвшин зантай явж болох аавын хүч би

Амиа хичээн харь газар доншуучилсан алдас бий, өршөө намайгаа!

Эрчилсэн цагаан хуйтай эргээд ирлээ би чинь

Эх орон минь, ээх нар минь намайгаа өршөө!

Алаг зүрхэндээ гуниг суутал санахын эрхээр

Атийхын давааны наадтайд эргээд ирлээ хүч чинь, өршөө намайгаа!

Газрын цээжинд шингээ гэж хэлэх эрх надад байхгүй

Гишүүныг туулж гандаж хөхөрсөн хүн ардтай барьцах эрх надад байхгүй

Ганцхан мөргөх минь, гал, сар, нарыг барьж мөргөх минь

Эх орны тул нөхчигсдөөс тэртээ доор

Энгийн нэгэн явагсдаас бүүр доор

Элэг, яс минь эх орноо хожуу ч гэсэн ухаарсныг бодож

Элэнхий болсон биеийг минь хөрсөндөө шингээж үз!

Эх орон минь

Ээх сүүлчийн нар минь, өршөө, намайгаа өршөө!

ГОЛЖ ЯВСАН ЭХ ОРОН ЧИНЬ . . .

Холын холыг харж байж зорьсондоо хүрдэг
Хонд бууцнаасаа гарч байж эр болдог
Дуулсан болгон үнэн байдаггүй
Дуулгатай болгон баатар байдаггүй
Цэлмэг өдөр дөрөө харшуулсан бүхэн
Цэлгэрхэн энэ орчлонг туулахад нөхөр болдоггүй
Цээний цэцэг шиг охид бүсгүйчүүд гунхавч
Цэрвүү холын замд тэр болгон нь ханилдаггүй. .

Гоочтой нэг үр л голомт залгаж нэрийг чинь мөнхөлдөг
Гомдоож явсан хань чинь бүхнийг мартан хөлийг чинь хучдаг
Гоомой юм шиг нөхөр чинь сүлчийн өдөр ясыг чинь барьдаг
Голж явсан эх орон чинь харин хэнийг ч алагчлалгүй хөрсөндөө
өлгийддөг.

Гоо хээнцэр бүхний нулимс өнгөндөө мэлмэрэвч
Горьгүй бэрхийн цагт цогцос дээр чинь унахгүй
Голын эхний буурал шинэс шиг болсон аав ээж чинь үлдсэн бол
Голоо тасраагүй хором бүрд чамайг гэсээр хорвоог элээдэг.

1994 оны 5 сарын 24-25 Мягмар-Лхагва

ЭРХИЙ ДАРАМ ГАЗАР /найраглал/

Бодлын хэлхээс

Он цагийн мөрөн урснам
Орчил дунд нь би ч бас урснам
Эргэж буцдаггүй цагийн эх мөрнөө
Эх орон тэр аяараа урснам.
Жаран, жарны түүүхийг уул усанд бичиглэж
Жаргал зовлон хоёр ээлж ээлжээр дамнаж
Жавхлант төрийн баганыг үе үеэр түшсэний
Жаргах нь үгүй цадигийг
Буурал түүх хүчрнэнэм.

1.Түүхийн хүчрнэл.

-Хүч минь чи балчир байна
Хүчрнэхийн учрыг тэвчин сонс
Хүннү нарын аймаг

Хүчтэй хорин дөрвөн холбооноос тогтож байсан юм.
Цинь улсын хаан ШиХуан
Цэрэглэж дандаа халддаг байсан юм
Манай эриний өмнөх хоёр зуун арван таван онд
Мэн Тянь жанжнаараа их цэрэг захируулан
Умардын Хүннүг даруулахаар илгээж
Уудам тал нутгаас минь урж тасдан авсан
гэдэг юм.

Өлмий хүрсэн газартаа хятад суурин байгуулж
Өмнөдийн иргэдийг суурьшуулсан гашуун үнэн
бий юм.

Түгшүүрт энэ цед Түмэн Шаньюй
Түрхрэх их чимээг сонссонгүй
Хайртай бага хатныхаа отгон хүч
Хаан ширээнд залахсан гэхээс нойр хомс. . .
Их хатны ууган хүч Модунийг
Юэчжэ аймагт суулгасан мөчөөс нойр бүтэн . . .

-Дараа нь бас Шаньюйн зарлигаар
Дайран довтолж Юэчжэ аймгийг түйвээх. . .
Уулгалан довтолсны хариу золионоо
Ууган хүч нь цаазын илдэнд унах. . .
. . . Хирдхийн цочихгүй зоригт Модунь

Халдах аюулаас сугаран зайлсан нь гайхамшиг
Үнэнд гүйцэтгдсэн эцэг Шаньюй
Юэчжэ аймагтай зэрэглэх хязгаарт
Жанжин болгосон нь гутамшиг.

Галд орж мэсэнд шүргүүлж явахдаа Модунь
Ганцхан авхаалж самбаа дайчин чадварыг шүтжээ.
Төмөр зэвт исгэрдэг сумаар
Түйвээн таригчдыг түвшитгэсэн гэдэг юм.

Эрэмгий шаламгай энэ жанжин

Эр цэрэгтээ зарлиг болруун:

-Дуут сумаа тавьсан зүг рүү минь хэн ч
байсан харва!

Дураар үлдэх хэнийг боловч цаазална. . .

Удаж төдсөн ч үгүй өөрөө манлайлж

Удамт сайн хүлээ харвав.

Эргэлзэн сүрдэх сумаа тавилгүй үлдсэн бүгдийг

Эзний тушаал зөрчсөн гэж хороов.

Дараагийн удаа ав шувуунд явахдаа

Дуут сумаа хатны зүг илгээжээ.
Айн ширвээтсэн зориглоогүй бүхнийг
Амийг нь хороож хэлсэндээ хүрчээ.
Ав хомрогын улс давхилдан ахуй цест
Аав Шаньюйн зүг дуут сум илгээв.
Араалдан дагах Модуний шадар цэргүүд
“Амь насыг” нь цэглэж тушаалыг гүйцээв.
Хүч Модунь эцгийг харвасны хойно
“Хүннүг” тогтоохын тул ийн болов
Хайрын сайнаар эцэг үрс болдогч
Хамаг одны тул төмөр нүүр гаргадаг гэв.
Зарлигийг дагаж цэргийг хүчирхэгжүүлж
Залуу Модунь Шаньюй болов.
Өрхийг түвшитгэж, улсыг хүчирхэгжүүлж
Өөрийнхөө араас Хүннүг дагуулав.

Бодлын хэлхээс

Он цагийн мөрөн урснам
Орчил дунд нь би ч бас урснам
Эргэж буцахгүй цагийн их мөрнөө
Эх орон минь тэр аяараа урснам
Жаран, жарны түчхийг уул, ус нь бичиглэж
Жаргал, зовлон хоёрыг хойч үе нь дамнаж
Жавхлант төрийн баганыг үе, үеэр түшсэний
Жаргах нь үгүй цадигийг буурал түцх хүчрэнэм. .

2. Түчхийн хүчрнэл

Хүч минь чи балчирхан байна
Хүний ухаан гүйцээгүй байна
Төрийг тогтооход шалгарсан зориг
Түйвээнийг дарахад ухаанаар хатаждаг юм.
Модунь Шаньюй алба үүсгэж суутал
Морьтой элч довтолгон ирж. . .
Дунху улсын хүчиндээ эрдэж
Дуртгах бичгийг ийн илгээжээ:
-Эцэг Шаньюйнхээ мянган ли хурдалдаг хүлгийг
Энэ элчээр явуул! гэжээ.
... Ордоны газар зөвлөлгөөн болж
Олон түшмэд зээглэн сууж
Ахлах түшмэл ам нээж:

Агт морийг битгий өг
 Арцан тулалдахад бэлтгэе! гэв.
 Модунь Шаньюй бодолхийлснээ:
 -Ганц морийн харамнаас
 Гаслан зовлонд унах ч юм билүү?
 Хаяа хатгасан хөршдөө
 Хармын сэтгэл гаргаад яана гэв.
 Хурдан хөлгийг элч хөтөлж
 Хуйлрах тоос үлдээн одов. . .
 . . . Удалгүй бас элч ирж,
 Уулгалан дайрах сүр үзүүлж:
 “-Хатдынхаа нэгийг өг”
 Хариуг элчээр явуул! гэж. .
 Модунь Шаньюйн шадрууд цуглаж
 -Морь, бас хатан авна гэнээ
 Мордоцгооё! Дунхуг довтолж гэжээ.
 Модунь Шаньюй бодолхийлснээ:
 -Хаяа хатган оршицгоож байж
 Хатан харамлаад чиг яахав даа
 Хүннү улс тогтнож байсан цагт
 Хүчхэн хүн олдолгүй яахав, өгье! гэжээ.
 Зарсан элч хэргээ бүтээж
 Замын тоос боссоор үлдэв. . .
 Дунху нар удсан ч үгүй
 Дуу дуулалдах нь сонсогдох болов
 Хүннүгийн захаас нутаг гишгээж
 Хүссэний хэрээр тасалж эхлэв.
 Даан удалгүй элч ирж
 Дайчин баатар шиг эрэмгий ханхалзаж:
 -Харуулын овооны эзгүй газрыг
 Хариу бодолгүй манайд өг! гэж. .
 Модунь Шаньюй шадруудтайгаа зөвлөж
 Монгол ухаан гаргаач гэв.
 -Эзэнгүй нутгийн зах шүү дээ энэ чинь
 Эрхий дарам газар шүү дээ тэгээд
 Хүлгээ өгсөн юм, хатнаа өгсөн юм
 Хүннү нар энүүхнийг харамнах нь ичгэвтэр биш үү? гэж.
 Зарим шадрыг үгээ гүйцээгээгүй байхад:
 -Эрхий дарам газар ч улсын үндэс
 Эзэн хэнд боловч зориг, зүрхийн уг

Сэмлүүлсэн нутагтай хүн жаргахыг би үзээгүй
Сэрүгээ та нар гэж Модуний зандрах сонсогдов.
Газар нутгаа өгье гэсэн бүхний толгой
Ганцхан хормын дотор бөндгөсхийн унав.
Бахардсан Шаньюй цэргээ хөдөлгөж
Бардам Дунхуг уландаа гишгэв.
Булаалгасан бүх нутгаа эргүүлэн авч
Булхайт хан улсыг эрхэндээ оруулав.

Түчүхийн гэрч: "... Хятадын Цинь улсыг залган тогтсон Хан улс /МЭӨ 206-220/ Хүннүг хүчирхэг болж буйд сэтгэл түгшин ажигж аль болох ойрхон хугацаанд дарж авахыг хүсэх болжээ. МЭӨ 200 онд Модунь Шаньюй Хятадын довтлон ирсэн 300.000 цэргийг хиаар цохижээ. Хан улсын Гао-Цзу хаан арга буюу ялагдсанаа хүлээж МЭӨ 198 онд Хүннү улстай найрамдлын гэрээ байгуулж "... Цагаан хэрэмнээс хойших нум, сум агсагчдын улс нь Шаньюйн зарлигийг дагаж, Цагаан хэрэмнээс урагш түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь надад захирагдана. ... Хан улс, Хүннү хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг улсууд юм гэж гэрээ ёсоор Хятад Монгол угсаатны түчүхэн хил цагаан хэрмээр тогтоогдож Хан улс Хүннү улсад жил бүр алба төлөх болжээ."

Бодлын хэлхээс

Он цагийн мөрөн урснам
Орчил дунд нь би ч бас урснам
Эргээж буцахгүй цагийн их мөрнөө
Эх орон минь тэр аяараа урснам
Жаран жарны түчүхийг уул, ус нь бичиглэж
Жаргал зовлон хоёрыг хойч үе нь дамнаж
Жавхлант төрийн баганыг үе, үеэр түшсэний
Жаргах нь үгүй цадигийг буурал түчүх хүчүрнэнэм

3. Түчүхийн хүчүрнэл:

Жаргах тутам сэрэмж чухаг
Зовох тутам зориг чухаг
Хаан хүн харийн хатадаас сэргийл
Харц хүн хар хулгайнаас сэргийл
-Мэсийн үзүүрт гартаж яваагүй хаан Модунь байлаа
Мэхтэн бүхнийг сөгтгөж явсан хаан Модунь байлаа
Мэнэнгийн их талд төөрч үзээгүй хаан

Модунь байлаа
 Мэнэрцүлсэн их халуунд цухалдаж үзээгүй хаан
 Модунь байлаа
 Монгол гүрний алтан төрийн бодлогыг тогтоож өгсөн хаан
 Модунь байлаа
 Морьтон нүцдэлчдийн дотроос Хан улсыг сөхрүцлсэн нь Модунь
 байлаа
 Монголын эртний төр улс хүчтэй явсан нь Модунь хааных байлаа
 Хуя нь овгийг мандуулж чадсан нь Модунь
 Шаньюй байлаа
 Хул шаргал түххийн тоосонд мартагдах үгүй нь Модунь Шаньюй
 байлаа
 Хувь тавилангийн эргэлт, гашуун бүхнийг амссан нь Модунь
 Шаньюй байлаа
 Хуурамч инээд, башир аргад гэндсэн нь
 Модунь Шаньюй байлаа.

4.Өгцүлэх нь:

Хаш цэцгэн ордны цөөрөм
 Халуун зундаа нугастай
 Хаан эзний өлмийг
 Хатадын харц дагаастай
 Зургаар болдог хорвоод
 Зуйгуур хүмүүс олон
 Зул цэцэг шиг бүсгүйчүүл ч
 Зүлэг ногоо шиг ганддаг буй. . .
 Гао-Цзу хаан нойр сэнсэрч
 Гаран орон бодлогоширно.
 Саран ханьсах шөнийн цэцэрлэгт
 Санаа алдан ганцаар алхална
 -“Модунь сэрүүн тунгалагтаа хүргэн чинь байна.
 Мориноосоо хагацсаны хойно таны зээ чинь Шаньюй болно.
 Нагацаасаа том эрхтэй улс гэж
 Нартад ер нь дуулдсан уу үгүй юу? . .
 Умардын зэрлэгчүд уусаж арилна
 Улсын маань нар тэгэхэд мандана”
 Зөвлөх түшмэл Лю Цзиний үг
 Зөв үү? Буруу юу? эргэж бодно. . .
 . . . Үнэн боллоо! үнэн боллоо!
 Үг хэлгүй номхруулж авлаа

Үхсэн Модунь Шаньюйн ширээний төлөө
Үр удам нь талцан бослоо! . . .
Хүннү, Хан хатадын хүүхдүүд
Хөрстийг хөрөөтөл тэмцэлдэж гарлаа!
Баатар хааны зовж байж тогтоосон төр улс
Балгад хэрэм мэт нурахыг үзлээ.
Бардамнах хагарахын гашуун үр нь
Басан хомголзогчдын бахыг хангалаа.

Бодлын хэлтээс :

Он цагийн мөрөн урснам
Орчил дунд нь би ч чи ч бас жрснам
Эргэж буцахгүй цагийн их мөрнөө
Эх орон минь тэр аяараа урснам
Жаран жарны түүхийг уул, ус нь бичиглэж
Жаргал зовлон хоёрыг хойч үе нь дамнаж
Жаварт түүхийн шуурганд унаж босож үлдсэний
Жаргах нь үгүй цадигийг буурал түүх хүүрнэнэм.

5.Түүхийн хүүрнэл:

Хаан хүний хайрлах ганц юм нь газар шороо
Хаан хүний харамлах ганц юм нь газар шороо
Хаан хүний сэрэмжлэх ганц юм нь хатад, эмс
Их монголын төрийн жолоог атгасан бүхэн
Энэ жолоог хэн атгаж явлаа гэдгийг
Сэрэнгэдээ тэнгэрээс асуу!
Сэтгэлдээ түүхээс асуу!
Хүннү, Нирун, Монголын их гүрэн
Хүрсэн гурван оргил гь байлаа
Зарц байж чадахгүй хүнийг
Залж байж эзэн болгодог даваа энэ биш шүү!
Хоёр мянганы тэртээх монгол төрийн ухаан
Холбоо залгаа болсоор өнөөдөр хүрсэн биш үү!
Хаан хүн жаргал хөөвөл
Хаан хүн хуйвалдаанд оролцвол
Хамаг ард шударгагүй болно биш үү!
Эрхий дармаар газар нутгаа сэмлүүлсээр
Эх орноо алдсан гашуун сургамж бий биш үү!

1994.06.18.